



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний
ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох журам,
мэргэжлийн зэргийн шалгалтын комиссыг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох журам”-ыг 01 дүгээр хавсралтаар, “Мэргэжлийн зэргийн шалгалтын комиссын бүрэлдэхүүн”-ийг 02 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Мэргэжлийн зэргийн шалгалтын комиссын үйл ажиллагааг зохион байгуулах, төсвийн дагуу гарган зарцуулахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого, зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/981 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 22 ны өдрийн
4155 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДАД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх, мэргэжлээрээ шатлан дэвших байнгын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй, найдвартай ажиллагааг сайжруулах шаардлагын дагуу энэхүү журмыг боловсруулсан.

1.2. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаа болон түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Мэргэжлийн зэрэг нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажлын байр, албан тушаалд хүний нөөцийг сонгон шалгаруулах, томилон ажиллуулах үндсэн шалгуурын нэг байна.

1.4. Мэргэжлийн зэргийн шаардлага ажилтнуудад ижил тэгш тавигдана.

Хоёр. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажлын байрны мэргэжлийн зэргийн шаардлага

2.1. Ахлах болон багш нислэгийн удирдагчийн ажлын байранд ажиллах нислэгийн удирдагч нь мэргэжлийн II, I зэрэгтэй байна.

2.2. Ерөнхий нислэгийн удирдагч, хэсэг, тасгийн ахлагч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний мэргэжилтэн, удирдах албан тушаалтан нь мэргэжлийн I дүгээр зэрэгтэй байна.

Гурав. Мэргэжлийн зэрэг горилогчид тавигдах шаардлага

3.1. Мэргэжлийн зэрэг горилогчид дараах үндсэн шаардлагууд тавигдана.

Үүнд:

3.1.1. Мэргэжлийн I зэрэг авахад:

- а. Нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;
- б. Мэргэжлийн II зэрэгтэй байх;
- в. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн II зэрэг эзэмшсэний дагуу 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
- г. Мэргэжлийн I зэргийн шалгалтыг амжилттай өгсөн байх;

3.1.2. Мэргэжлийн II зэрэг авахад:

- а. Нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй;
- б. Мэргэжлийн III зэрэгтэй байх;

в. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн III зэрэг эзэмшин 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;

3.1.3. Мэргэжлийн III зэрэг авахад:

а. Нислэгийн удирдагч мэргэжилтэй, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлтэй байх;

б. Нислэгийн удирдагчийн үнэмлэх, зэрэглэлийн дагуу 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;

в. Мэргэжлийн III зэргийн шалгалтыг амжилттай өгсөн байх;

г. Мэргэжлийн II зэргийн шалгалтыг амжилттай өгсөн байх;

3.2. Мэргэжлийн зэрэг горилогчид 4.1-д зааснаас гадна дараах нэмэлт шаардлагуудыг тавина. Үүнд:

а. Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй байх;

б. Сүүлийн 1 жилийн хугацаанд нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлхүйц алдаа дутагдал гаргаагүй байх.

3.3. Мэргэжлийн зэрэг горилогч нь доорх нөхцөлийг хангасан талаар Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын тодорхойлолт, саналын дагуу мэргэжлийн зэргийн шалгалтын комисс дүгнэлт гарган шалгалт өгөх хугацааг 2 хүртэл жилээр урагшлуулан тогтоож болно. Үүнд:

3.3.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн шинэ санал, төсөл санаачлан дэвшүүлж, уг санаачилга нь зохих үр дүнгээ өгч хэрэгжсэн;

3.3.2. Удаа дараагийн нислэгийн онцгой нөхцөл, тохиолдлын үед мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажилласан

3.4. Мэргэжлийн зэргийг алгасуулан олгохгүй.

Дөрөв. Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс

4.1. Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба комиссын бүрэлдэхүүнийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар батална.

4.2. Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь мэргэжлийн зэргийн шалгалт авах огноо, үргэлжлэх хугацаа, байршлыг тогтооно.

4.3. Мэргэжлийн зэргийн шалгалтын комиссын бүрэлдэхүүн шалгалтын тест боловсруулж, баталгаажуулж, нууцлал хадгалах үүрэг хүлээнэ.

Тав. Мэргэжлийн зэргийн шалгалт

5.1. Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь мэргэжлийн зэргийн шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

5.2. Мэргэжлийн зэргийн шалгалтын зарыг шалгалт эхлэхээс 2 сараас багагүй хугацааны өмнө зарлан мэдээлсэн байна.

5.3. Мэргэжлийн зэргийн горилогчийг шалгалт эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө бүртгэж дууссан байна.

5.4. Мэргэжлийн зэргийн шалгалтыг дараах хэлбэрээр авна. Үүнд:

а. Тестээр мэргэжлийн онолын мэдлэгийг шалгах эсхүл

б. Асуулт хариулт бүхий албан ярилцлагаар.

5.5. Мэргэжлийн зэрэг гориллогчийн мэргэжлийн зэргийн шалгалтын дүн, материалыг Мэргэжлийн зэргийн комисс хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар зэрэг олгох, эс олгох шийдвэрийг гарган, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар олгоно.

5.6. Мэргэжлийн зэргийн тухайн шалгалтад тэнцээгүй гориллогч дараагийн ээлжит шалгалтад орж болно.

Зургаа. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл

6.1. Мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцэж зэргийн шаардлагыг хангасан ажилтнуудад мэргэжлийн зэргийн нэмэгдлийг дор дурдсанаар үндсэн цалингаас бодож тооцон сар бүр олгоно. Үүнд:

- а. Мэргэжлийн I дүгээр зэрэг - 15 хувь
- б. Мэргэжлийн II дугаар зэрэг - 10 хувь
- в. Мэргэжлийн III дугаар зэрэг - 5 хувь

Долоо. Мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа

7.1. Энэхүү журмын дагуу олгогдсон мэргэжлийн зэрэг нь хуулийн дагуу түдгэлзүүлсэн, эсхүл Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар хүчингүй болгоогүйгээс бусад тохиолдолд хүчинтэй байна.

7.2. Мэргэжлийн зэргийг дараах тохиолдолд, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар бууруулна. Үүнд:

- а. Зэрэг тогтоолгон ажиллах хугацаандаа нислэгийн хөдөлгөөний зөрчил гаргаж түүнийгээ мэдээлээгүй нуун дарагдуулсан бол;
- б. Зэрэг эзэмших хугацаандаа сахилгын зөрчил гаргасан бол.

7.3. Мэргэжлийн зэрэг буурсан ажилтан дараагийн мэргэжлийн зэргийн шалгалтад зэрэг горилж болно.

Найм. Бусад зүйл

8.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнууд мэргэжлийн зэргийг тодорхойлсон ялгах тэмдгийг хэрэглэх ба ялгах тэмдэг нь дүрэмт хувцасны бүрэлдэхүүн хэсэг байна.

8.2. Энэхүү журамд заагдаагүй нөхцөл байдал үүсвэл Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс хэлэлцэн шийдвэрлэнэ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
А.Б. дугаар тушаалын 02 дугаар хавсралт



МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТЫН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын
навигацийн үйлчилгээний газрын дарга

Нарийн бичгийн
дарга: Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын
навигацийн үйлчилгээний газрын менежер

Гишүүд: Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны
дарга

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны
захиргаа, хүний нөөц, сургалтын хэсгийн дарга

Монголын нислэгийн удирдагчдын холбооны
тэргүүн

---oOo---